



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2021 оны 03 сарын 09 өдөр

Дугаар 61

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл  
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 9 дэх заалт, 25 дугаар зүйлийн 1 дэх заалт, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1.б дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.2 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Сүхбаатар аймагт барьж ашиглалтад оруулсан нийт 15,000,000.00 (арван таван сая) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан цэвэр ус, ариутгал татуургын шугамыг Сүхбаатар аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны төрийн нарийн бичгийн дарга Д.Ганболд, Сүхбаатар аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн дарга Х.Энхбаяр, Орон нутгийн өмчийн газрын даргыг үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Алтансүх нарт тус тус дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бodoх бүртгэл, тайланд тусгах, хүлээнлэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ


ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

13201012

\Huraldaanii material\2021 on\2021.03.09 4r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2021 оны 03 дугаар сарын 09...ны өдрийн  
..... дугаар тогтоолын хавсралт



**Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон  
Сүхбаатар аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний газарт  
бүртгэх хөрөнгийн жагсаалт**

Д/д	Барилга , байгууламж /хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний/-ний нэр	Хүлээн авч ашиглах төсөвт байгууллагын нэр	Хөрөнгийн үнэ (төгрөг)
1	Цэвэр, ариутгал татуургын шугам	Сүхбаатар аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний газар	15,000,000.00
	Нийт дүн		15,000,000.00 <i>/арван таван сая төгрөг/</i>